| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 24,484,030.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 17,176,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 17,176,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 459,273,485.45 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 459,273,485.45 |

| | | |
|---|---|---|
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 12,610,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 12,610,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 30,820,000.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 30,820,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 30,820,000.00 |
| II | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 911,011,119.66 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 911,011,119.66 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 197,631,015.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 626,247,124.07 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 87,132,980.59 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Орхон аймгийн Эрүүл мэндийн газар нь Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд чиглэгдсэн нийтийн эрүүл мэнд, эмнэлгийн тусламж, үйлчилгээний нэр төрлийг төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад нэмэгдүүлэх, чанар хүртээмжийг сайжруулах,салбарын хөренгө оруулалт, санхүүжилтийг оновчтой төлөвлөх, салбар нэгжийг удирдлагаар хангах,бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, үр дүнтэй, бодитой төлөвлөлт хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, дүгнэлт гаргах, бодлого боловсруулах асуудлыг хамарсан үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Эрүүл мэндийн сайдын харьяа байгууллага юм.

Үйл ажиллагааны эрхэм зорилго нь "Нийтийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлж, олон улсын чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлнэ" гэж тодорхойлж, дараах зорилтуудыг дэвшүүлсэн байна. Үүнд:

- Нийгмийн эрүүл мэндийн цогц бодлогыг хэрэгжүүлэх, иргэдийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, оношилгоонд тогтмол хамруулах, нотолгоонд суурилсан эрүүл мэндийг дэмжих бодлогыг хэрэгжүүлэх.
- Хог хаягдлын менежментийг сайжруулж, орчны сөрөг нөлөөллийг бууруулах, эрүүл мэндийн цогц арга хэмжээг бусад салбарын дэмжлэгтэй хэрэгжүүлэх.
- Халдварт өвчний тандалт, сэргийлэлт, бэлэн байдал, хариу арга хэмжээг уян хатан, шуурхай зохион байгуулах чадавхыг бэхжүүлж, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, дархлаажуулалтын үйл ажиллагааг өргөжүүлэх, салбар хоорондын оролцоо, халдварт өвчнийг хамтын ажиллагаанд тулгуурлан бууруулах.
- Уламжлалт, сэргээн засах, хөнгөвчлөх, сувилахуйн тусламж үйлчилгээг цогц, нэгдмэл байдлаар хөгжүүлж, тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх
- Төр, хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх, хувийн хэвшлийн эмнэлгүүдийн чадавхыг нэмэгдүүлэх, тусламж үйлчилгээний тасралтгүй шуурхай байдлыг хангаж хамтран ажиллах
- Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлыг хангаж, эмнэл зүй, эм зүйн тусламж үйлчилгээг хөгжүүлэх, нянгийн тэсвэржилтийг судалж, антибиотикийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн хяналтыг сайжруулах.

Чиг үүргийг Эрүүл мэндийн тухай хуульд зааснаар дараах байдлаар тусгажээ. Үүнд:

- Эрүүл мэндийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газар, нутгийн өөрөө удирдах байгууллага, Засаг даргаас гаргасан шийдвэрийн биелэлтийг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах
- Харьяалах нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавих
- Харьяалах нутаг дэвсгэрийн хүн амын эрүүл мэндийн статистик мэдээлэл, эрүүл мэндийн байгууллагын тайлан, мэдээ, мэдээллийг нэгтгэн холбогдох байгууллагад өгөх.
- Орон нутгийн төрийн захиргааны бүх шатны байгууллага, төрийн бус байгууллагуудын идэвх санаачилга, олон улсын улсын байгууллагуудын дэмжлэг туслалцаа, иргэд, аж ахуйн нэгжийн байгууллагын оролцоотойгоор нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж чанарыг сайжруулах
- Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэх чадавхыг бэхжүүлэх

- Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг төлөвлөх, эрүүл мэндийн ажилтны ур чадвараа тасралтгүй хөгжүүлэх боломжийг нэмэгдүүлж, нийгмийн баталгааг сайжруулан, тэдний эрүүл аюулгүй тав тухтай ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх
- Эрүүл мэндийн салбарт цахим үйлчилгээг өргөжүүлэн, эрүүл мэндийн мэдээллийн сан бүрдэн, орон нутагт хийгдэх оношилгоо эмчилгээнд алсын зайн технологи ашиглаж, цахим эрт илрүүлэг, эргэн дуудах тогтолцоог бүрдүүлэх
- Эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалт, санхүүжилтийг оновчтой төлөвлөх, үр ашгийг нэмэгдүүлж, эрүүл мэндийн байгууллагыг гүйцэтгэлд суурилсан санхүүжилтэд шилжүүлэх
- Эрүүл мэндийн салбарын удирдлагын чадавхыг нэмэгдүүлж, эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааны менежментийг сайжруулах

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар тайлант онд санхүү нягтлан бодох бүртгэлдээ дараах хууль тогтоомж, дүрэм журмыг мөрдөж ажилласан байна. Үүнд:

- Монгол улсын Үндсэн хууль
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль;
- Захиргааны ерөнхий хууль;
- Эрүүл мэндийн тухай хууль;
- Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль;
- Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль;
- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль;
- Нийгмийн эрүүл мэндийн тухай хууль
- Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого;
- Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл;
- Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр;
- Төсвийн тухай хууль
- Зөрчлийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын А/191 дүгээр тушаал
- Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын А/192 дугаар тушаал
- Сангийн сайдын 120 дугаар тушаал
- Шилэн дансны тухай хууль
- Төрийн аудитын тухай хууль
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Засгийн газрын 382 дугаар тушаал
- Сангийн сайдын 388 дугаар тушаал

- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"

Тайлант онд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомжид дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуульд 6, Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2, Хөдөлмөрийн тухай хуульд 3, Төрийн албаны тухай хуульд 6 удаагийн нэмэлт өөрчлөлт орсон байна.
- 2024 оны 03 сарын 27-ны өдрийн Монгол улсын Засгийн газрын 128 дугаар тогтоолоор "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээ"-г шинэчлэн тогтоож 2024 оны 04 дүгээр сарын 01-ээс мөрдөж эхэлсэн.
- Монгол улсын Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 83 дугаар тогтоолын дагуу "Төрийн захиргааны албан хаагчдад 5 жил тутамд 6 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгох журам"-г мөрдөж эхэлсэн.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж дүгнэлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 337,888.2 мянган төгрөгөөр буюу 4.10 хувиар өсжээ.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Авлага | 8,094,454.9 | 5,051,942.9 | (3,042,512.0) |
| Бараа материал | 590,010,125.5 | 426,794,946.1 | (163,215,179.4) |
| Үндсэн хөрөнгө | 7,300,625,919.7 | 7,804,771,784.8 | 504,145,865.1 |
| **Нийт хөрөнгө** | **7,898,730,500.1** | **8,236,618,670.8** | 337,888,170.7 |
| Өр төлбөр | - | 8,142,584.2 | 8,142,584.2 |

| Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн | 7,925,502,737.2 | 8,236,618,778.2 | 311,116,041.0 |
|---|---|---|---|

Тайлант онд авлагын данс (3,042,512.0) мянган төгрөг болж буурсан нь нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг төлсөнтэй холбоотой байна.

Бараа материалын дансаар (163,215,179.4) мянган төгрөгийн тусгай зориулалтын материал, эм боох материал, бэлэн бүтээгдэхүүн, түлш, шатах тослох материал зарцуулснаас шалтгаалж дансны үлдэгдэл 426,794.9 мянган төгрөг болж буурчээ.

Аймгийн хөрөнгө оруулалтаар 3 өрхийн эрүүл мэндийн төвд 594,875.8 мянган төгрөгийн их засвар, 38,789.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж хандиваар авсантай холбоотой үндсэн хөрөнгийн данс 7,236,618.6 мянган төгрөг болж өссөн байна.

Ерөнхий Сайдын 05-р албан даалгаврын хүрээнд тэвчиж болох зардлын зүйлээр зарцуулах эрхийг олгоогүйгээс шалтгаалан өр төлбөрийн данс 8,142.6 мянган төгрөгөөр нэмэгдэх шалтгаан болжээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 4,353,952.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн бөгөөд төсвийн захирагчийн боловсруулсан саналыг 1,126,988.0 мянган төгрөгөөр бууруулан 3,299,327.4 мянган төгрөгөөр баталсан байна.

Энэ нь хөрөнгө оруулалтын шинж чанартай 1,126,988.0 мянган төгрөгийн зардлыг төсөвт тусгасантай холбоотой байна.

Тайлант онд батлагдсан төсвийн хуваарьт 1 удаа өөрчлөлт орсонтой холбоотой 88,246.1 мянган төгрөгөөр бууруулан тодотгож 3,138,718.2 мянган төгрөг болж өөрчлөгдсөн байна.

Тайлангийн жилд батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж жилийн эцэст 104,861.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээг санхүүжүүлэхээр 3,020,183.5 мянган төгрөгийн санхүүжилтийг улсын төсвөөс олгосон байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 3,020,183.5 мянган төгрөгийн санхүүжилт авч урсгал үйл ажиллагаанд 1,915,322.6 мянган төгрөг зарцуулж, 104,860.9 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн бөгөөд төсвийн гүйцэтгэл 91.4 хувьтай байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

| Д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,008,982.8 | 97,668.4 | 34,314.4 | 96.60 |
| 2 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 145,515.2 | 123,022.1 | 22,493.1 | 84.54 |
| 3 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 73,820.8 | 73,820.8 | 0 | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 4 | Хангамж, бараа материалын зардал | 18,476.6 | 16,950.4 | 1,526.2 | 91.74 |
| 5 | Норматив зардал | 478.1 | 418.5 | 59.6 | 87.53 |
| 6 | Эд хогшил, урсгал засварын зардал | 3,397.8 | 2,944.7 | 453.1 | 86.66 |
| 7 | Томилолт, зочны зардал | 5,268.7 | 4,830.6 | 438.1 | 91.68 |
| 8 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 7,156.4 | 6,021.6 | 1,134.8 | 84.14 |
| 9 | Бараа үйлчилгээний бусад зардал | 6,470.3 | 6,461.1 | 9.2 | 99.86 |
| 10 | Бусад урсгал шилжүүлэг | 1,869,151.5 | 1,706,184.4 | 162,967.1 | 91.28 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Нэмэлт санхүүжилтээр нийт 911,011.1 мянган төгрөгийн орлого бүртгэж тайлагнасан байна. Үүнд:

Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөцөөс хөрөнгөөс 626.247,1 мянган төгрөг, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-аас 111,372.6 мянган төгрөг, НҮБ-ын хүүхдийн сангаас 52,733.5 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 87,132.9 мянган төгрөг, бусад байгууллагаас 33,525.0 мянган төгрөгийн санхүүжилтийг тус тус бүртгэлд тусгаж 910,903.68 мянган төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулж 107.42 мянган төгрөгийг төвлөрүүлжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Орхон аймгийн Засаг дарга, Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хүүхдийн Сангийн суурин төлөөлөгчийн хамтын ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд "хүний папиллома вирусын халдварын эсрэг дархлаажуулалтын хамралтыг нэмэгдүүлэх" төсөл арга хэмжээний зардалд 18,100.0 мянган төгрөг, "хүн амын бүлгүүд нярайн захын судсаар төвийн венийн гуурс тавих" төсөлд 23,933.5 мянган төгрөг, "Орбис интернэшнл" олон улсын байгууллагатай хамтран "Насанд хүрэгчдийн нүдний эмгэг" төслийг 10,700.0 мянган төгрөг, аймгийн Засаг дарга, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-тай хамтран "Цагаан тоосны дэгдэлт, сөрөг нөлөөллийг бууруулах хөтөлбөр"-ийг Баян-Өндөр сумын Баянцагаан баг, Говил баг, Жаргалант сумын Дулаан-Уул баг, Улаантолгой баг, Жаргалант багуудын иргэдийг хамруулан 9 удаагийн үйл ажиллагаа зохион байгуулж, 1510 иргэнийг хамруулж 80,000.0 мянган төгрөгийг тус тус зарцуулжээ.

### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Орхон аймгийн Эрүүл мэндийн газар нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, дотоод хяналтын үр нөлөөг дээшлүүлэх, санхүүгийн бүртгэл, тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Азжаргал гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Буян-Ундрах, дарга, тэргүүлэх аудитор П.Пүрэвлхагва нар тус тус хэрэгжүүлсэн.

2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01/34 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

**4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Материаллаг байдлыг 2025 оны батлагдсан төсвийн 3,226,964.3 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 33,883.1 мянган төгрөгөөр тооцсон бөгөөд гүйцэтгэлийн шатанд шинэчлэгдсэн төсвийн 3,138,718.2 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 32,956.5 мянган төгрөгөөр дахин хянаж шинэчлэн тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага төсвийн зарлагыг өмнөх оны төсвийн гүйцэтгэлээс хэтрүүлэхгүй зарцуулалт хийсэн байна.

Төрийн хэмнэлтийн тухай хууль, Санхүүгийн тайлангийн аудит хийхэд баримтлах ерөнхий бодлого, чиглэлийн дагуу тухайн байгууллагын үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах, хяналт тавихын зэрэгцээ гарч болох эрсдэлийг төлөвлөгөө, гүйцэтгэлд тусгасан бөгөөд байж болох хувилбарыг түүвэрлэн авч горим сорил хэрэгжүүлсэн.

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалтай. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 159 талбарын мэдээллээс 159 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд нийцлийн асуудлыг үнэлэх асуудал үүсээгүй болно. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Тэргүүлэх аудиторын 2025 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн 300 дугаар албан тоотын дагуу завсрын аудитыг 2025 оны 09 дүгээр сарын 17-нд эхлүүлсэн.

2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд завсрын аудит хийж илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудлын бүртгэл хөтөлж, шалгагдагч байгууллагад танилцуулсан.

Завсрын аудитаар нийт 18,123.0 мянган төгрөгийн 3 зөрчил илэрснээс жилийн санхүүгийн тайлангийн аудитаар зөрчлийн биелэлт хангагдаагүй тул тайлант оны буруу илэрхийлэлд оруулан тооцож, 728.6 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 13,520.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 3,874.4 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өглөө.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт хангагдсан байна.

2025 оны санхүүгийн тайлангийн аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Азжаргал хийж гүйцэтгэсэн бөгөөд аудитаар нийт 33,609.4 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 842.2 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 14,889.8 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, 17,877.4 мянган төгрөгийн 5 зөвлөмж өгсөн бөгөөд биелэлтийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 01/234, 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 01/418 тоотоор тус тус ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Төлбөрийн акт | 2 | 842.2 | 2 | 842.2 | 100 |
| Албан шаардлага | 1 | 14,889.8 | 1 | 14,889.8 | 100 |
| Зөвлөмж | 5 | 17,877.4 | 5 | 17,877.4 | 100 |
| **Нийт дүн** | **8** | **33,609.4** | **8** | **33,609.4** | **100** |

**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

2025 оны санхүүгийн тайланд алдаа илрээгүй залруулга хийгээгүй.

Аудитаар нийт 14,159.5 мянган төгрөгийн зөрчил[1] илэрснээс 965.0 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 13,194.5 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

**5.1 Төлбөрийн акт**

Байгууллагын төсвөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авсан, тайлант онд цалин илүү бодож олгосон 965.0 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоов.

**5.2 Албан шаардлага**

Албан шаардлага өгөөгүй

**5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал**

<u>**Илрүүлэлт:**</u>

Тус байгууллага нь 2017 оноос хойш Нягтлан бодох бүртгэлийн баримт бичгийг шинэчлэн батлаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйл "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн удирдлага, зохион байгуулалт" 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана"

***Өгсөн зөвлөмж:***

Шинэчлэгдэн гарсан хууль журамтай нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн баримт бичгийг шинэчлэн боловсруулан баталж, мөрдөх.

2. **Авлагатай холбоотой асуудал**

<u>**Илрүүлэлт:**</u>

Төсвийг зохистой удирдаагүй оны эцэст 5,051.9 мянган төгрөгийн ажилчидтай холбоотой авлага үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

еренхийлен захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэж заасантай нийцэхгүй байна.

*__Зөвлөмж:__*
Төсвийг зохистой удирдаж авлага үүсгэхгүй байх.

**3. Авлагатай холбоотой асуудал**

__Илрүүлэлт:__

Ерөнхий Сайдын 05-р албан даалгаврын хүрээнд тэвчиж болох зардлын зүйлээр зарцуулах эрхийг олгоогүйгээс 8,142.5 мянган төгрөгийн байгууллагатай холбоотой өглөг үүссэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5 "хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь батлан хэрэгжүүлэх" гэж заасантай нийцэхгүй байна.

*__Зөвлөмж:__*
Төсвийг зохистой удирдаж өр төлбөр үүсгэхгүй байх.

Дээрх Төлбөрийн акт, албан шаардлагын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үндэс: Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Тайлант онд 790.0 мянган төгрөгийн цалин илүү бодож олгосон байна. | 1 | 790.0 | 1 | 790.0 | | | | | | | | |
| Тус байгууллага нь 2017 оноос хойш Нягтлан бодох бүртгэлийн баримт бичгийг шинэчлэн батлаагүй байна. | 1 | 0 | | | | | 1 | 0 | | | | |
| Төсвийг зохистой удирдаагүй оны эцэст 5,051.9 мянган төгрөгийн ажилчидтай холбоотой авлагатай байна. | 1 | 5,051.9 | | | | | 1 | 5,051.9 | | | | |
| Ерөнхий Сайдын 05-р албан даалгаврын хүрээнд тэвчиж болох зардлын зүйлээр зарцуулах эрхийг олгоогүйгээс 8,142.5 мянган төгрөгийн байгууллагатай холбоотой өглөг үүсэн байна. | 1 | 8,142.5 | | | | | 1 | 8,142.5 | | | | |
| **Дүн** | **4** | **13,984.4** | **1** | **790.0** | | | **3** | **13,194.4** | | | | |

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөг/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үндэс: Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт** | | | | | | | | |
| **Дүн** | | | | | | | | |
| **Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт** | | | | | | | | |
| Байгууллагын төсвөөр 175.0 мянган төгрөгийн бэлэг дурсгалын зүйл худалдан авсан байна. | 1 | 175.0 | 1 | 175.0 | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Дүн | 1 | 175.0 | 1 | 175.0 | | | | |

ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
**ТӨЛБӨРИЙН АКТ**

2026 оны 02 дугаар 12 сарын Дугаар 78/А14-70337 ОРА-2026/02/НА-СТА-7243 Баян-Өндөр сум

## ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Орхон аймгийн Эрүүл мэндийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсвийн хөрөнгөөр 175,000 (Нэг зуун далан таван мянган) төгрөгийн бэлэг дурсгалын зүйл худалдан авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.5-д "хариуцлагатай байх", 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.5-д "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.3.3-д "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Орхон аймгийн Эрүүл мэндийн газар нь төсвийн хөрөнгөөр 175,000 (Нэг зуун далан таван мянган) төгрөгийг Орхон аймгийн Төрийн сан дахь 100210000988 тоот (Ор.Хүү торгуулийн орлого) дансанд төвлөрүүлэх.

612511258

2. Актын биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт[1] ирүүлэхийг Орхон аймгийн Эрүүл мэндийн газрын дарга (Ц.Мөнхцэцэг), нягтлан бодогч (Н.Чулуун-Эрдэнэ) нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР..............................П.ПҮРЭВЛХАГВА

АУДИТЫН
МЕНЕЖЕР..............................Б.БУЯН-УНДРАХ

АУДИТОР..............................Б.АЗЖАРГАЛ

[1] Монгол улс, Орхон аймаг, Баян-Өндөр сум, Хүрэн булаг баг, Нутгийн удирдлагын ордон, Утас: 7035-9826

ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
**ТӨЛБӨРИЙН АКТ**

2026 оны 02 дугаар 12 сарын

Дугаар 54/А1470537
ОРА-2026/102/НА-СТА-ТИЗ

Баян-Өндөр сум

## ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Орхон аймгийн Эрүүл мэндийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд 790,000 (Долоон зуун ерэн мянган) төгрөгийн цалин илүү бодож олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.5-д "хариуцлагатай байх", 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4-д "үнэн зөв байх", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.3.3-д "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Орхон аймгийн Эрүүл мэндийн газар нь илүү олгосон 790,000 (Долоон зуун ерэн мянган) төгрөгийг Орхон аймгийн Төрийн сан дахь 100210000988 тоот (Ор.Хүү торгуулийн орлого) дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт[1] ирүүлэхийг Орхон аймгийн Эрүүл

[1] Монгол улс, Орхон аймаг, Баян-Өндөр сум, Хүрэн булаг баг, Нутгийн удирдлагын ордон, Утас: 7035-9826

612511?55

мэндийн газрын дарга (Ц.Мөнхцэцэг), нягтлан бодогч (Н.Чулуун-Эрдэнэ) нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР:......................................П.ПҮРЭВЛХАГВА

АУДИТЫН
МЕНЕЖЕР:......................................Б.БУЯН-УНДРАХ

АУДИТОР:......................................Б.АЗЖАРГАЛ